| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 3,764.0            | 3,749.0            |
| 210808      | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж                   | 300.0              | 240.0              |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>184,898.0</b>   | <b>80,642.4</b>    |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 182,118.0          | 77,935.4           |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 2,780.0            | 2,707.0            |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                  | 14,587.3           | 14,587.3           |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 5,000.0            | 4,837.5            |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>  | <b>344,185.9</b>   | <b>323,496.5</b>   |
| 220001      | Барилга байгууламж   | 344,185.9          | 323,496.5          |
| <b>III</b>  | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>1,518,881.9</b> | <b>1,418,626.2</b> |
| <b>31</b>   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                       | <b>222,390.1</b>   | <b>0.0</b>         |
| 310004      | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих                      | 222,390.1          | 0.0                |
| <b>32</b>   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                | <b>1,165,934.0</b> | <b>1,359,267.8</b> |
| 320001      | Орон нутгийн төсвөөс   | 1,165,934.0        | 1,142,570.9        |
| 320002      | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих                              | 0.0                | 216,696.9          |
| <b>35</b>   | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>                         | <b>130,557.8</b>   | <b>59,358.4</b>    |
| 350001      | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 102,690.5          | 58,458.4           |
| 350002      | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 1,000.0            | 900.0              |
| 350003      | Урьд оны үлдэгдлээс санхүүжих  | 26,867.3           | 0.0                |

|   |   |     |          |
|---|---|-----|----------|
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 0.0 | 26,867.4 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 73,341.2 |

## 2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан (мянган төгрөгөөр)

| Код    | Үзүүлэлт   | ТЗ цэвэр дүн |
|--------|--|--------------|
| II     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН  | 10,329.5     |
| 21     | УРСГАЛ ЗАРДАЛ  | 10,329.5     |
| 210    | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ  | 10,329.5     |
| 2108   | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж   | 10,329.5     |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 10,329.5     |
| I      | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР   | 10,329.5     |
| 1311   | Нэмэлт санхүүжилтийн орлого  | 10,329.5     |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,329.5     |
| III    | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)   | 0            |
| 9      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл   | 0            |
| 10     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл  | 0            |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жинст сум нь “Жинстчууд бид эрүүл, чинээлэг, хөгжсөн иргэнтэй, байгальд ээлтэй хөдөө аж ахуй, байгаль орчин, аялал, жуулчлал, үйлдвэрлэл үйлчилгээг цогцоор нь хөгжүүлсэн эдийн засгийн чадамжтай Их богд бүсийн төв, улсын жишиг сум болно” эрхэм зорилготой ажилласан байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд хүний хөгжлийн дээдлэн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй дэмжиж иргэдийг тогтвортой ажлын байраар хангах, ядуурлыг бууруулахад төрийн байгууллагын бодлого, үйл ажиллагааг чиглүүлэх стратегийн зорилтыг хэрэгжүүлэх байгууллагын эрхэм зорилтыг дэвшүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Жинст сумын төсөвт байгууллагуудын мөрдөж байгаа Баянхонгор аймгийн СТХС-ээс 2021 онд бэлтгэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь

холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Жинст сумын Засаг даргын харьяа байгууллагууд, тусгай сангийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жинст сумын Засаг даргын 2023 санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,279,490.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 693,069.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                                     | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт         |
|--|--------------------|--------------------|------------------|
| Б  | 1                  | 2                  | 3=2-1            |
| Мөнгөн хөрөнгө                               | 73,857.6           | 124,156.8          | 50299.2          |
| Авлага                                       | 193442.1           | 134,550.8          | (58891.3)        |
| Бараа материал                               | 17.768.3           | 43074.5            | 25306.2          |
| Нөөцийн бараа                                | 9800.0             |                    | (9800.0)         |
| Үндсэн хөрөнгө                               | 984.622.1          | 1.670.777.4        | 686.155.3        |
| Хуримтлагдсан элэгдэл                        | (598.144.2)        | (638.893.8)        | 40.749.6         |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>1.279.490.0</b> | <b>1.972.559.6</b> | <b>693.069.6</b> |
| Өр төлбөр                                    | 0                  | 0                  | -                |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 1.279.490.0        | 1.972.559.6        | 693.069.6        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>1.279.490.0</b> | <b>1.972.559.6</b> | <b>693.069.6</b> |

Эх сурвалж: Жинст сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 73,857.6 мянга, эцсийн үлдэгдэл 124,156.8 мянган төгрөг болж 50,299.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                   | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|----------------------------|----------------|-----------------|------------------------|-----------------|
| Касст байгаа бэлэн мөнгө   | 0              | 0               | 0                      | 0               |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 73,857.5       | 124,156.8       | 50,299.3               | 59%             |

|                             |                 |                  |                 |             |
|-----------------------------|-----------------|------------------|-----------------|-------------|
| Орон нутгийн ерөнхий орлого | 46,990.2        | 50,815.6         | 3,825.4         | 91.1%       |
| Орон нутгийн хөгжлийн сан   | 26,795.8        | 14,996.2         | (-11799.6)      | 55.9%       |
| Хоршоо хөгжүүлэх сан        | 71.5            | 58,344.9         | 58,273.4        | 81.6%       |
| Замд яваа мөнгөн хөрөнгө    | 0               | 0                | 0               | 0           |
| Хадгаламж                   | 0               | 0                | 0               | 0           |
| <b>ДҮН</b>                  | <b>73,857.5</b> | <b>124,156.8</b> | <b>50,299.3</b> | <b>100%</b> |

Эх сурвалж: Жинст сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 124,156.8 мянган төгрөгийн 59 хувь буюу 50,815.6 мянган төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл бол 55,9 хувь буюу 14,996.2 мянган төгрөгийн нь ОНХС-ийн харилцах дансны үлдэгдэл, 81.6 хувь буюу 58,273.4 мянган төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл байна.

Төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын данс дахь 50,815.6 мянган төгрөг байгаагаас 23,363.1 мянган төгрөг нь төсөвт байгууллагуудын оны эцэст буцааж төвлөрүүлсэн төвлөрүүлэх шилжүүлэг, 27,452.5 мянган төгрөг нь орон нутгийн орлого давснаас шалтгаалан төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

### 3.4.2 Авлага

Оны эхний 193,442.1 мянган төгрөгийн авлага 58,891.3 мянган төгрөгөөр буурсан нь оны эцэст 134,550.8 мянган төгрөгийн авлагатай гарчээ.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл / мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                  | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---------------------------|------------------|------------------|------------------------|-----------------|
| Бусад авлага              | 0                | 0                | 0                      | 0               |
| Хувь хүмүүст олгосон зээл | 193,442.1        | 134,550.8        | -58,891.3              | 100             |
| <b>ДҮН</b>                | <b>193,442.1</b> | <b>134,550.8</b> | <b>-58,891.3</b>       | <b>100</b>      |

Эх сурвалж: Жинст сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт авлагын 100 хувийг Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хувь хүмүүст олгосон зээл авлага эзэлж байна.

### 3.4.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 17,768.3 мянга, эцсийн үлдэгдэл 43,074.5 мянган төгрөг болж, 25,306.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                    | Эхний үлдэгдэл  | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|-----------------------------|-----------------|-----------------|------------------------|-----------------|
| Тусгай зориулалтын материал | 340.0           | 340.0           | 0                      | 00              |
| Эм боох материал            | 70.0            | 70.0            | 0                      | 00              |
| Бичиг хэргийн материал      | 868.5           | 527.0           | (341.5)                | 0.5             |
| Аж ахуйн материал           | 700.0           | 700.0           | 0                      | 0               |
| Сэлбэг хэрэгсэл             | 700.0           | 700.0           | 0                      | 0               |
| Мал амьтад                  |                 | 20,209.7        | 20,209.7               | 25              |
| Барилгын засварын материал  | 618.0           | 618.0           | 0                      | 0               |
| Бусад хангамжийн материал   | 14,019.8        | 19,357.8        | 5,338.0                | 8.4             |
| Нөөцийн бараа               | 9,800.0         |                 | 9,800.0                | 15.8            |
| <b>Дүн</b>                  | <b>17,768.3</b> | <b>43,074.5</b> | <b>25,306.2</b>        | <b>100</b>      |

Эх сурвалж: Жинст сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан



Тайлант онд 49,356.1 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 20,209.7 мянган төгрөгийн бараа материал бусад байгууллагаас үнэ төлбөргүй шилжиж авч, үйл ажиллагаанд 44,259.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

#### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,582,766.2 мянга, эцсийн үлдэгдэл 2,309,671.2 мянган төгрөг болж, 726,905.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                      | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өсөлт (+),<br>Бууралт (-) | Дүнд<br>эзлэх<br>хувь |
|-------------------------------|--------------------|--------------------|---------------------------|-----------------------|
| Барилга байгууламж, орон сууц | 757,174.4          | 1,225,103.6        | 467,929.2                 | 62.6                  |
| Тээврийн хэрэгсэл             | 122,536.1          | 196,638.9          | 74,102.8                  | 9.1                   |
| Машин тоног төхөөрөмж         | 240,161.6          | 264,664.6          | 24,503.0                  | 5.1                   |
| Тавилга эд хогшил             | 55,086.4           | 55,886.5           | 0                         | 1.6                   |
| Номын фонд                    | 520.0              | 520.0              | -                         | 0.1                   |
| Бусад үндсэн хөрөнгө          | 392,719.2          | 552,269.2          | 159,550.0                 | 20.3                  |
| Программ хангамж              | 3,700.0            | 3,700.0            | -                         | 0                     |
| Бусад биет бус хөрөнгө        | 10,868.5           | 10,868.5           | -                         | 0                     |
| <b>Дүн</b>                    | <b>1,582,766.3</b> | <b>2,309,671.2</b> | <b>726,085.0</b>          | <b>100</b>            |

Эх сурвалж: Жинст сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант он ЗДТГ-т төсвийн хөрөнгөөр 9,249.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 104,280.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад байгууллагаас шилжүүлэн авч, сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 15,854.6 мянган төгрөгийн барилга, 78,941.3 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг акталсан.

#### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1,279,490.0 мянга, эцсийн үлдэгдэл 1,972,559.6 мянган төгрөг болж, 693,069.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өмнөх үеийн үр дүн дансны үлдэгдэл өмнөх оноос 694,556.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүн 697,644.1 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан.

#### 3.4.7 Орлогын данс

Жинст сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 12/07 дугаар тогтоолоор сумын татварын орлогыг 312,992.0 мянга, татварын бус торгуулийн орлогыг 4,000.0 мянган, нийт 316,992.0 мянган төгрөгөөр баталсныг сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын тогтоолоор цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21,610.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж татварын орлогыг 334,602.1 мянган төгрөгөөр баталжээ.

Хүснэгт 11. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөгөөр/

| Орлогын нэр                            | Төлөвлөгөө       | Гүйцэтгэл        | Зөрүү           | Хувь         |
|--|------------------|------------------|-----------------|--------------|
| <b>Хувь хүний орлогын албан татвар</b> | <b>160,610.0</b> | <b>186,097.9</b> | <b>25,487.9</b> | <b>115.9</b> |
| 1. Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого | 127,710.0        | 151,028.2        | 23,318.2        | 118.3        |
| 2. Үйл ажиллагааны орлого              | 16,000.0         | 14,962.4         | (1,037.6)       | 93.5         |
| 3. ҮХЭХ борлуулсны орлого              | 3,000.0          | 2,010.0          | (990.0)         | 67.0         |
| 4. Хадгаламжийн хүү                    | 13,900.0         | 18,097.3         | 4,197.3         | 130.2        |
| <b>Өмчийн татвар</b>                   | <b>3,040.0</b>   | <b>2,507.8</b>   | <b>(532.2)</b>  | <b>82.5</b>  |
| 1. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 1,900.0          | 1,337.8          | (562.2)         | 70.4         |
| 2. Бууны албан татвар                  | 1,140.0          | 1,170.0          | 30.0            | 102.6        |

|                                      |                  |                  |                 |              |
|--------------------------------------|------------------|------------------|-----------------|--------------|
| <b>Бусад татвар, төлбөр хураамж</b>  | <b>164,752.0</b> | <b>167,794.7</b> | <b>3,042.7</b>  | <b>101.8</b> |
| 1. Улсын тэмдэгтийн хураамж          | 11,000.0         | 279.4            | (10,720.6)      | 2.5          |
| 2. Газрын төлбөр                     | 5,200.0          | 1,473.2          | (3,726.8)       | 28.3         |
| 3. Түгээмэл тархацтай АМНАТ          | 500.0            | 3.3              | (496.7)         | 0.7          |
| 4. Малын тоо толгойн албан татвар    | 95,000.0         | 94,060.0         | (940.0)         | 99.0         |
| 5. Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 7,900.0          | 9,338.8          | 1,438.8         | 118.2        |
| 6. Ус рашаан ашигласны төлбөр        | -                | -                | -               | 0            |
| 7. Ан амьтны нөөц ашигласны төлбөр   | 45,152.0         | 62,640.0         | 17,488.0        | 138.7        |
| 8. Газрын дуудлага худалдааны орлого | 6,200.0          | 3,962.6          | (2,237.4)       | 171.1        |
| <b>Татварын бус орлого</b>           | <b>4,000.0</b>   | <b>3,002.6</b>   | <b>(997.4)</b>  | <b>75.1</b>  |
| 1. Төсөвт байгууллагын өөрийн орлого | 1,200.0          | -                | (1,200.0)       | -            |
| 2. Торгуулийн орлого                 | 1,000.0          | 960.0            | (40.0)          | 96.0         |
| <b>Орлогын нийт дүн</b>              | <b>334,602.0</b> | <b>360,363.0</b> | <b>25,761.0</b> | <b>107.7</b> |

Эх сурвалж: Жинст сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 115.9 хувь буюу 25,487.9 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн нь дараах орлогууд давж биелсэнтэй холбоотой байна. Үүнд:

- Тайлант онд төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 118.3 хувиар биелсэн.

- Ан агнуурын орлого 45,152.0 мянган төгрөг төлөвлөснөөс шонхрын орлого 62,640.0 мянган төгрөг орж 17,880.0 мянган төгрөгөөр давсан байна.

Харин улсын тэмдэгтийн хураамжийн орлого 11,000.0 мянган төгрөг оруулахаас 279.4 мянган төгрөг орсон нь орлогыг үндэслэлгүй төлөвлөсөнтэй холбоотой байна. Газрын төлбөрийн орлого 3,726.6 мянган төгрөгөөр тасарсан нь тус суманд Ингэний фермер байгуулах зорилгоор 40 га газрыг олгосон ч үйл ажиллагаа эхлээгүйгээс газрын төлбөр ороогүй байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогыг сумын ИТХ батлахдаа сумын ЗДТГ өөрийн орлогоор 1,000.0 мянга, Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл, хүүгийн эргэн төлөлтийн орлогоор 102,690.5 мянган төгрөг оруулахаас гүйцэтгэлээр сумын ЗДТГ орлогыг 90 хувь биелүүлж, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.

Хүснэгт 12. Өөрийн орлого /мянган төгрөгөөр/

| № | Сумын нэр | Байгууллагын нэр  | Төлөвлөгөө       | Гүйцэтгэл       | Зөрүү             | Хувь       | Өөрийн орлогын эх үүсвэрийн талаар тайлбар |
|---|-----------|-------------------|------------------|-----------------|-------------------|------------|--|
| 1 | Жинст     | ЗДТГ              | 1,000.0          | 900.0           | (100.0)           | 90%        |  |
| 2 | Жинст     | Сум хөгжүүлэх сан | 102,690.5        | 58,458.4        | (44,232.1)        | 43%        | Зээлийн хүү, эргэн төлөлт                  |
|   |           | <b>ДҮН</b>        | <b>103,690.5</b> | <b>59,358.4</b> | <b>(44,332.1)</b> | <b>43%</b> |  |

Эх сурвалж: Жинст сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.4.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1,518,881.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,372,152.4 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 1,048,655.9 мянган төгрөгийг урсгал зардалд, 323,496.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Жинст сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг 2 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, улсын төсвийн байгууллагын тогтмол зардлыг төлөвлөж аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 10/67 дугаар тогтоолоор сумын төсвийн нийт зардлыг 1,288,655.8 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн тогтоолоор анх 1,288,655.8 мянган төгрөгөөр баталсан, анхны төсөвт сумын ИТХ-ын хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 12/04 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийж, урьд оны үлдэгдлийг 230,226.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,518,881.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 12. Жинст сумын Засаг даргын 2023 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэр /мянган төгрөгөөр/

| №   | Үзүүлэлт   | Анхны баталсан<br>2022.12.19 өдрийн<br>10/67 тогтоол | Сумын ИТХ-ын<br>2023.07.05-ны<br>өдрийн 12/04 тогтоол |
|-----|--|--|---|
| 1   | Татварын орлого                                  | 312,992.0  | 329,602.0   |
| 2   | Татварын бус орлого /торгуулийн орлого/          | 4,000.0  | 4,000.0   |
| 3   | Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг         | 648,147.9  | 785,342.6   |
| 4   | Сумын төсөвт аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг    | 197,753.9  | 222,390.1   |
| 5   | Өөрийн орлого ЗДТГ                               | 1,000.0  | 1,000.0   |
| 6   | Өөрийн орлого Хоршоо хөгжүүлэх сан               | 102,690.5  | 102,690.5   |
| 7   | Сумын төсвийн урьд оны үлдэгдэл                  | 22,000.0   | 46,990.1  |
| 8   | Сумын ОНХС-ийн урьд оны үлдэгдэл                 |  | 26,795.8  |
| 9   | Сумын хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдэл | 71.5   | 71.5  |
| ДҮН |  | 1,288,655.8  | 1,518,881.9   |

Эх сурвалж. Жинст сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 12/07, 2023 оны 15/03 дугаар тогтоол

Тайлант онд 1,518,881.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,372,152.4 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулсан байна.

Хүснэгт 13. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөгөөр/

| №   | Байгууллагын нэр | Төлөвлөгөө  | Гүйцэтгэл   | Зөрүү     | Хувь | ОНТ-т төвлөрүүлсэн |
|-----|------------------|-------------|-------------|-----------|------|--------------------|
| 1   | ЗДТГ             | 589,686.3   | 584,856.5   | 4,829.8   | 99%  | 4,829.8            |
| 2   | ИТХ              | 122,479.0   | 121,067.6   | 1,411.4   | 99%  | 1,411.4            |
| 3   | ЕБС              | 173,741.3   | 173,199.4   | 541.9     | 100% | 541.9              |
| 4   | Цэцэрлэг         | 28,876.9    | 27,921.9    | 955.0     | 97%  | 955.0              |
| 5   | ЭМТ              | 45,590.8    | 45,444.9    | 145.9     | 100% | 145.9              |
| 6   | Соёлын төв       | 111,559.7   | 95,980.6    | 15,579.1  | 86%  | 15,579.1           |
| 7   | ОНХС             | 344,185.9   | 323,496.5   | 20,689.4  | 94%  |                    |
| 8   | СХС              | 102,762.0   | 185.0       | 102,577.0 | 0%   |                    |
| ДҮН |                  | 1,518,881.9 | 1,372,152.4 | 146,729.5 | 90%  | 23,463.1           |

Эх сурвалж: Жинст сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,372,152.4 мянган төгрөг буюу 90 хувьтай байгаа нь тогтмол зардлыг 17,221.9 мянган төгрөгөөр хэмнэсэн, ОНХС-аас хэрэгжүүлэн төсөл арга хэмжээг 20,689.4 мянган төгрөгөөр дутуу хэрэгжүүлсэн, Сум хөгжүүлэн сангаас олгохоор төлөвлөсөн зээлийг олгоогүй, зээлийн эргэн төлөлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Жинт сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 9,059.5 мянга, ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 1,300.0 мянга, нийт 10,329.5 мянган төгрөгийн санхүүжилт орсноос бараа үйлчилгээний бусад зардалд 10,329.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Сумын ИТХ-аас ОНХС, Хоршоо хөгжүүлэх сангаас өөр хэрэгжсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Жинст сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, үе шатны дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Жинст сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024.03.05-ны өдөр ирүүлсэн байна.

Жинст сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 1 дүгээр гарын үсгийг сумын Засаг дарга Р.Батжаргал, 2 дугаар гарын үсгийг сумын санхүүгийн албаны дарга П.Наранбаатар нар зурж хөрөнгийг захиран зарцуулсан байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны баталсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлыг 1,265,501.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 11,265.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,885.5 мянган төгрөгөөр тогтоосон, төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Жинст сумын Засаг даргын харьяаны төсөвт байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласнаар дараах зардлуудыг хэмнэсэн байна. Үүнд:

- Байр ашиглалттай зардал 17,563.6 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Жинст сумын Засаг даргын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 89 мэдээлэл оруулахаас 89 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Жинст сумын ЗДТГ, ИТХ-ын санхүүгийн тайланд ахлах аудитор М.Алтантуяа, тусгай сангуудын санхүүгийн тайланд аудитор Н.Бүнчинсүрэн, Д.Цэдэвцэвээн нар завсрын аудитыг гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар илэрсэн дээрх зөрчлийг төсөвт байгууллага, тусгай сангийн санхүүгийн тайланд залруулж арга хэмжээг авч ажилласан байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Жинст сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр 44,406.2 мянган төгрөгийн зөрчил илэрч 19,154.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 25,251.5 мянган

төгрөгийн 3 албан шаардлага өгснөөс 10,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 14 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                 | Биелэлт  |                 |              |
|-----------------|------------------------|-----------------|----------|-----------------|--------------|
|                 | Тоо                    | Дүн             | Тоо      | Дүн             | Хувь         |
| Төлбөрийн акт   | 1                      | 19,154.7        | 1        | 19,154.7        | 100%         |
| Албан шаардлага | 3                      | 25,251.5        | 2        | 15,251.5        | 66.6%        |
| Зөвлөмж         |                        |                 |          |                 |              |
| <b>Нийт дүн</b> | <b>4</b>               | <b>44,406.2</b> | <b>4</b> | <b>34,406.2</b> | <b>77.5%</b> |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

#### 4.7 Аудитын гол асуудал

Сумын Засаг даргын харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Жинст сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн ЗДТГ нь “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт авч, ИТХ болон 2 тусгай сангийн санхүүгийн тайлан түүвэрт хамрагдаж, сумын Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төвийн орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт, гүйцэтгэл төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдсэн байна.

Жинст сумын Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 497,710.3 мянган төгрөгийн 6 алдаа<sup>1</sup> илэрснээс 4,154.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 493,556.3 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлсэн.

Хүснэгт 15. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн

/мянган төгрөгөөр/

| № | Байгууллагын нэр | Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга  | Мөнгөн дүн | Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | Материаллаг эсэх | Зөрчлийн ангилал |
|---|------------------|---|------------|-----------------------------|------------------|------------------|
| А | 1                | 2   | 3          | 4                           | 5                | 6                |
| 1 | Жинст сумын ЗДТГ | Сумын Засаг даргын 2023.07.20-ны өдрийн “100 жилийн ойн баярыг угтан бэлтгэл хангуулах тухай” А/101 дугаар захирамжаар 2,500.0 мянган төгрөгөөр цагаан идээ бэлтгэсэн   | 2,500.0    | Төлбөрийн акт               | Материаллаг      | Санхүүгийн аудит |
| 2 | Жинст сумын ЗДТГ | Жинст сумын ЗДТГ-ын газар эзэмших гэрчилгээг нягтлан бодох бүртгэл, аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн судалгаатай тулган шалгахад 241093 мкв талбай бүхий 12 газар байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлгүй, үүнээс тэжээлийн ургамлын талбай, бэлчээр дэх уст цэг, мал эмнэлгийн үйлчилгээний зориулалттай 7 газар нь | 0          | Төлбөрийн акт               | Материаллаг бус  | Санхүүгийн аудит |

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

|                          |                  |  |           |                       |                 |                  |
|--------------------------|------------------|--|-----------|-----------------------|-----------------|------------------|
|                          |                  | газрын гэрчилгээ, газар эзэмшүүлэх байгуулаагүй байна. гэрээ   |           |                       |                 |                  |
| ДҮН                      |                  |  | 2,500.0   |                       |                 |                  |
| 3                        | Жинст сумын ОНХС | Жинст сумын ИТХ-аар баталсан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад байхгүй 1,654,000.0 (Нэг сая зургаан зуун тавин дөрвөн мянга) төгрөгийн үнийн дүнтэй "Согтуурлын зэрэг тогтоох багаж нийлүүлэх гэрээ"-г сумын Засаг дарга "Айети юнипикэшн" ХХК-тай 2023 оны 12 дугаар сарын 22-ын өдөр байгуулж санхүүжилтийг олгосон байна..                                       | 1,654.0   | Төлбөрийн акт         | Материаллаг     | Санхүүгийн аудит |
| 4                        | Жинст сумын ОНХС | Жинст сумын 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтын 2.1-т тусгасан Бохирын машинтай болох төсөл арга хэмжээгээр сумын ОНХС-аас 37,500,000 төгрөгийн үнэ бүхий бохирын машиныг 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр иргэн Ц.Хоролсүрэнгээс хүлээн авсан ба одоог хүртэл бохирын машины эзэмшигчийн гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлж аваагүй байна. | 37,500.0  | Албан шаардлага өгсөн | Материаллаг бус | Санхүүгийн аудит |
| 5                        | Жинст сумын ОНХС | Сумын ОНХС-аас хэрэгжүүлсэн нийт 8 төсөл арга хэмжээний 357,918,000.0 (Гурван зуун тавин долоон сая есөн зуун арван найман мянга) төгрөгийн хөрөнгийг сумын ИТХ-аар хэлэлцүүлж тогтоол гаргалгүй Засаг даргын захирамжаар төсөвт байгууллагын хөрөнгөд орлогоор бүртгэсэн байна.   | 357,918.0 | Албан шаардлага өгсөн | Материаллаг бус | Санхүүгийн аудит |
| 6                        | Жинст сумын ОНХС | Жинст сумын 2023 оны ОНХС-н шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 98,138,350 төгрөгийн зарлагын 7 гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.   | 98,138.3  | Албан шаардлага өгсөн | Материаллаг бус | Нийцлийн аудит   |
| ДҮН                      |                  |  | 495,210.3 |                       |                 |                  |
| НИЙТ АЛДАА, ЗӨРЧЛИЙН ДҮН |                  |  | 497,710.3 |                       |                 |                  |

Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын зөрчлийн нэгтгэл

### Аудитын илрүүлэлт

Аудитаар харьяа төсөвт байгууллагуудын санхүү төсвийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, хариуцлагыг дээшлүүлэх, төсвийн сахилга батыг дээшлүүлж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хэрэгжилтийг нотлох баримтын хамт 2024 оны 09 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл**

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |          | Үүнээс        |     |                 |     |          |          |
|--|-------------|----------|---------------|-----|-----------------|-----|----------|----------|
|  |             |          | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж  |          |
|  | Тоо         | Дүн      | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо      | Дүн      |
| Жинст сумын Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 497,710.3 мянган төгрөгийн 6 алдаа илэрснээс 4,154.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 493,556.3 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлсэн. | 1           | 0        |               |     |                 |     | 1        | 0        |
| <b>Нийт дүн</b>  | <b>1</b>    | <b>0</b> |               |     |                 |     | <b>1</b> | <b>0</b> |

---oOo---







سرور خان صاحب کو یہ خط لکھنا ہے کہ میں نے اس سے پہلے اس سے ملنا نہیں چاہا تھا

یہ خط لکھنا ہے کہ میں نے اس سے پہلے اس سے ملنا نہیں چاہا تھا

میں نے اس سے پہلے اس سے ملنا نہیں چاہا تھا

میں نے اس سے پہلے اس سے ملنا نہیں چاہا تھا